

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 12 дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар албан бичгийн хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ “АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 17

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулах хөрөнгө мян.төг	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг: ✓ а/байгууллагын албан ёсны цахим хуудас; ✓ б/сошиал сувгууд; ✓ в/дотоод сүлжээ; ✓ г/хэвлэл мэдээллийн хэрэгсэл; ✓ д/мэдээлэл;	-Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; -Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрд тайлагнадаг байх; -Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	Жилдээ	Сар бүр цахим хуудаст байршуулах	-	3 эх сурвалжаар нийт 12 удаа түгээн ажилласан. -Авлигын эсрэг хууль тогтоомжийн хүрээнд “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар” нэртэй фейсбүүк пейж хуудсаар дамжуулан 8 контент, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем “UB ERP”-ээр 110 дугаар, авлигын эсрэг шторкийг 4 удаа, Байгууллагын цахим хуудас (ub-procurement.mn)-т авлигын эсрэг цэс нээж, Авлигатай тэмцэх газрын цахим хуудас	100%

1	2	3	4	5	6	7	8	9
		<p>сурталчилгаа; ✓ самбар, лед дэлгэц ✓ e/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх;</p>					<p>(iaac.mn)-ыг холбож ажилласан. -Байгууллагын цахим хуудас (ub-procurement.mn), “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар” нэртэй албан ёсны фейсбүүк пейж хуудасны нүүр хэсэгт оруулж цахим хуудаст хандаж байгаа иргэд, олон нийт шууд танилцах боломжтойгоор байршуулсан.</p>	
		<p>1.2.Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>-Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; -Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; -Хамтран ажилласан байгууллага, хүний тоо; -Үр дүнг тооцсон байх.</p>	<p>Жилдээ</p>	<p>2 өдөрлөг, 1 аян</p>	<p>-</p>	<p>Энэхүү үйл ажиллагаанд төсөв батлагдаагүй бөгөөд тайлант хугацаанд энэ чиглэлийн ажил зохион байгуулагдаагүй болно.</p>	<p>-</p>

1	2	3	4	5	6	7	8	9
		<p>1.3.Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах.</p>	<p>-Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; -Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; -Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших;</p>	Сар бүр	1200 ш гарын авлага тараах	-	<p>Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын цахим хуудас (ub-procurement.mn) болон "Нийслэлийн Худалдан Авах Ажиллагааны Газар" нэртэй фейсбүүк пэйж хуудсаар дамжуулан дараах мэдээллийг түгээн ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> > Авлигын хор хөнөөл, шүгэл үлээх, авлигыг мэдээлэх 110 гомдол мэдээлэл хүлээн авах дугаарыг иргэд, олон нийтэд сурталчилсан 7 удаагийн постер, 6 видео мэдээ; > Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын талаарх видео мэдээлэл, хөтөлбөрийн төлөвлөлтийг сайжруулах тухай, "Төрийн багууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 3 шторк; > Байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан мөрдөгддөг хууль тогтоомжид заасан авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байгууллагын чиг үүргийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. 	80%
		<p>1.4.Өөрсдийн байгууллагын үйл</p>	<p>-Авлигын эрсдэлээс урьдчилан</p>	2,3 дугаар	12-оос доошгүй	-	<p>Байгууллагын нийт 32 албан хаагчийн компьютер, өрөө</p>	80%

1	2	3	4	5	6	7	8	9
		ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	сэргийлэхэд чиглэсэн байх; -Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх; -Олон нийтэд түгээсэн байх.	улирал д			тасалгаанд иргэд олон нийт харах боломжтой газруудад авлигаас ангид байх, авлигыг мэдээллээ, эрүүл нийгмийг цогцлооход таны оролцоо чухал зэрэг 15 төрлийн материал боловсруулан байршуулсан мөн 3 эх сурвалжаар нийт 12 удаа олон нийтэд авлигын эсрэг мэдээллийг түгээн ажилласан. -Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын "Шударга ёс, хөгжил дэвшилд 110 мэдээллийн самбар"-т Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө, хагас жилийн биелэлт, санал хүсэлтийн хайрцаг, Төрийн албан хаагчийн тангаргийг монгол бичгээр бичүүлж, "Авлигын эсрэг нэгдье" гэсэн уриаг байгууллагын хурлын өрөөнд байршуулж, Байгууллагын цахим хуудас (ub-procurement.mn)-т байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлтээ илгээх боломжтой талбарыг тус тус идэвхтэй ажиллуулж байна.	
2	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн	2.1."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх	-Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг	Жилдээ	1-ээс доошгүй	-	Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх хүрээнд журмын 4.1	100%

1	2	3	4	5	6	7	8	9
	хяналтыг хэрэгжүүлэх		хэрэгжүүлэхээр сонгосон байх; -Сонгосон чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх; -Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах; -Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх.				дэх заалтад зааснаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгарсан этгээд “Олон нийтийн хяналт хэрэгжүүлэгч хуульт ёс судалгааны төв” НҮТББ-тай Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн “Ажил гүйцэтгэх” (05-04/529) гэрээ байгуулан, ажлын 21 хоногийн хугацаанд хяналтыг хэрэгжүүлэн тус газраас холбогдох цахим хуудаст байршуулсан мэдээллийг 5 шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэхэд 94.2 оноог авсан. Энэ нь мэдээллийн ил тод, нээлттэй байдлын ангиллын үүднээс “Онц сайн” буюу (outstanding) үнэлгээгээр үнэлэгдсэн талаарх тайлан, зөвлөмжийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн АБ-2025/61 дүгээр албан бичгээр ирүүлсэн. Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулахаар ажиллаж байна.	
		2.2.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын	-Салбар бүрд үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; -Авлигаас урьдчилан	Жилдээ	4-өөс доошгүй	-	-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсэгт “Үнэлгээний хорооны гишүүний гуравны нэгээс доошгүй нь захиалагчаас хараат бус гишүүн	100%

1	2	3	4	5	6	7	8	9
		ажиллагааг нэмэгдүүлэх	сэргийлэх, соён гэгээрүүлэх иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; -Үр дүнг тооцож тайлагнасан байх.				байна.”, 50.5.Үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг сонгоно.” гэж тус тус заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газартай 2025 онд гэрээ байгуулан цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулсан Төрийн бус байгууллагын (цаашид “ТББ” гэх) 65 гишүүн, тус газарт 2025 онд үнэлгээний хорооны гишүүнээр (цаашид “ҮХГ” гэх) ажиллах хүсэлт ирүүлсэн 35 ТББ-ын гишүүн нийт 100 (давхардсан тоогоор) гишүүний судалгааг гаргаж, Газрын даргын 62 тушаалаар 396 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын 115 үнэлгээний хороонд 217 ТББ-ын төлөөлөл (давхардсан тоогоор)-ийг томилон захиалагчийн үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	
		2.3.Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн	-2025 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд	Жилдээ	12-оос доошгүй нээлттэй мэдээлэх	-	-Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлсэн захирамж болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас албан хүсэлтээр эрх шилжиж ирсэн 396 төсөл, арга хэмжээг Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем	100%

1	2	3	4	5	6	7	8	9
		<p>талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах</p>	<p>тогтмол ойлгомжтой байдлаар мэдээлэх; -Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч холбогдох арга хэмжээг авах; -Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээг хэрэгжүүлэх;</p>				<p>(www.tender.gov.mn)-д бүртгэж, төлөвлөлтөд оруулж, тендер шалгаруулалтын үйл явцын мэдээ, мэдээллийг 100 хувь нийтэлж ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д давхардсан тоогоор 341 төсөл, арга хэмжээний урилга, үр дүн нийтлэгдсэн байна.</p> <p>Тус газраас зарлаж буй төсөл, арга хэмжээний тендерийн нээлтийг “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар” фэйсбүүк хуудсаар 95 удаа хийж олон нийтэд нээлттэй мэдээлсэн.</p> <p>-Байгууллагын цахим хуудас (ub-procurement.mn)-т дараах цэсүүдэд нийт 196 мэдээ, мэдээллийг түгээн нийтэлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Үйлчилгээ цэс - 42; ✓ Бидний тухай - 8; ✓ Хууль, эрх зүй - 10; ✓ Ил тод байдал - 23; ✓ Тендер - 3; ✓ Авлигын эсрэг- 8; ✓ Холбоо барих-2; ✓ Мэдээ мэдээлэл –50; ✓ Цагийн үеийн мэдээ-20, ✓ 24 мега төслүүдийн 30 мэдээ мэдээллийг тус тус олон нийтэд түгээж ажилласан. <p>shilen.gov.mn цахим системд 4</p>	

1	2	3	4	5	6	7	8	9
							<p>чиглэлийн 86 үзүүлэлтээр улирал бүр тайлагнаж ажилласан бөгөөд дундаж үнэлгээ 84% байна.</p> <p>-Shilendans.mn цахим системд төсөв, гүйцэтгэл болон хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, бусад чиглэлээр тухай бүр, сар бүр, хагас жил, жил бүр оруулах нийт 142 мэдээллийг бүрэн оруулж, 2 мэдээг хугацаа хоцроож, оруулсан.</p> <p>Ангилан харуулбал:</p> <ul style="list-style-type: none"> ✓ сар бүр оруулах 36 мэдээлэл; ✓ тухай бүр оруулах 108 мэдээлэл. 	
		<p>2.4.Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших</p>	<p>-Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах;</p> <p>-Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших;</p> <p>-Иргэд олон нийтээс байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх;</p>	Жилдээ	2-оос доошгүй	-	<p>-Тайлант хугацаанд нийт 37 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй байна.</p> <p>Үнэлгээний хорооны хөндлөнгийн 35 гишүүнээс тендер зохион байгуулалт, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгааг QR кодыг ашиглан авч гарсан үр дүнг харгалзан үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна.</p> <p>-ҮХ-ны хөндлөнгийн гишүүдээс цалин урамшуулал нэмэгдүүлэх чиглэлээр 17, хурлын заалны хүртээмж, зохион байгуулалт болон бусад асуудлаар ирүүлсэн саналуудыг байгууллагын</p>	100%

1	2	3	4	5	6	7	8	9
							<p>удирдлагад танилцуулсны үр дүнд 1 хурлын өрөө нэмсэн.</p> <p>Байгууллагын цахим хуудас (https://ub-procurement.mn/)-т “Сэтгэл ханамжийн судалгаа” цэсийг бий болгож, үйл ажиллагаатай холбоотой санал, асуулга авахаар байршуулсан.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн танилцуулах сургалтыг Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-тай хамтран Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол дүүргүүдийн Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-ийн бизнес эрхлэгчдэд мөн Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Зорчигч тээвэр ОНӨААТҮГ зэрэг 5 байгууллагын 69 албан хаагчид зохион байгуулж, сэтгэл ханамжийн судалгаа авсан.</p>	
		<p>2.5.Улс, орон нутаг, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгох</p>	<p>-MNS 7023:2023 “Мэдээллийн самбар”-г тавигдах шаардлага бүхий үндэсний стандартын хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.</p>	<p>Жилдээ</p>	<p>Тухай бүр</p>	<p>-</p>	<p>-Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/277 дугаар захирамжаар “Томоохон (мега) төслүүдийн жагсаалт баталж, хэрэгжилт хангуулах тухай” жагсаалт баталсан үүний дагуу НЗД-ын захирамжаар эрх шилжүүлсэн мега төсөл, арга хэмжээний явц үр дүн, мэдээллийг Нийслэлийн Худалдан</p>	<p>100%</p>

1	2	3	4	5	6	7	8	9
							<p>авах ажиллагааны цахим хуудаст танилцуулга бэлтгэн тухай бүр иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй түгээн ажилласан.</p> <p>Мөн Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр нийт зарлаж буй төсөл, арга хэмжээний зарлал, явц, үр дүнг тухай бүр нийтлэн ажиллаж байна.</p> <p>Үүнд:</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Томоохон (мега) төслүүдийн жагсаалт баталж, хэрэгжилт хангуулах тухай” А/277 дугаар захирамжийн 10 мега төслийн хүрээнд Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн 16 захирамжийн 30 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын явц, үр дүнг харуулбал;</p> <ul style="list-style-type: none"> ✓ Гэрээ хийгдсэн -19; ✓ Гэрээ байгуулах эрх олгосон -3; ✓ Тендерийн материал хүлээн авч байгаа -1; ✓ Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа-1; ✓ Захирамжаар хүчингүй болсон-6; <p>Нийт 30 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын зарлалт 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс үр дүн гарч гэрээ байгуулах</p>	

1	2	3	4	5	6	7	8	9
							<p>эрх олгосон төсөл, арга хэмжээ 93 хувийн гүйцэтгэлтэй.</p> <p>Дундаж хэрэгжилт 94 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Газрын дарга, Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтсийн төлөөлөл, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга нар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд Сэлбэ дэд төв орон сууцны иж бүрэн хороолол мега төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын явц, үр дүнгийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд танилцуулан ажилласан.</p>	
3	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах</p>	<p>3.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>-Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар олон нийтээс судалгаа, санал асуулга авах;</p> <p>-Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх;</p> <p>-Хэрэгжилтийг тайлагнах.</p>	Жилдээ	4-оос доошгүй	-	<p>5</p> <p>-Үнэлгээний хорооны хөндлөнгийн 35 гишүүнээс тендер зохион байгуулалт, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгааг QR кодыг ашиглан авч гарсан үр дүнг харгалзан үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна.</p> <p>-Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүдээс цалин урамшуулал нэмэгдүүлэх чиглэлээр 17, хурлын заалны хүртээмж, зохион байгуулалт болон бусад асуудлаар ирүүлсэн саналуудыг байгууллагын удирдлагад танилцуулсны үр дүнд 1 хурлын ерөө нэмсэн.</p> <p>-Байгууллагын цахим хуудас</p>	90%

1	2	3	4	5	6	7	8	9
							<p>(https://ub-procurement.mn/)-т “Сэтгэл ханамжийн судалгаа” цэсийг бий болгож, үйл ажиллагаатай холбоотой санал, асуулга авахаар байршуулсан.</p> <p>-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн танилцуулах сургалтыг Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-тай хамтран Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол дүүргүүдийн Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-ийн бизнес эрхлэгчдэд мөн Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Зорчигч тээвэр ОНӨААТҮГ зэрэг 5 байгууллагын 69 албан хаагчид зохион байгуулж, сэтгэл ханамжийн судалгаа авч дараагийн сургалтуудад сайжруулалт хийн ажиллаж байна.</p> <p>-“Олон нийтийн хяналт хэрэгжүүлэгч хуульт ёс судалгааны төв” НҮТББ-аас цахим хуудаст байршуулсан мэдээллийг 6 шалгуурын 43 үзүүлэлтийн хүрээнд үнэлэхэд 94.2 оноог авсан бөгөөд мэдээллийн ил тод, нээлттэй байдлын ангиллын үүднээс “Онц сайн” буюу (outstanding) үнэлгээгээр үнэлэгдэж, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр төлөвлөгөө</p>	

1	2	3	4	5	6	7	8	9
							боловсруулан ажиллаж байна.	
		3.2.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	-Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших; -Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх; -Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх.	Жилдээ	Тухай бүр	-	-Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл тайлант хугацаанд гараагүй. -Хөндлөнгийн байгууллагаар эрсдэлийг тодорхойлуулах төсөв батлагдаагүй байна.	100%
		3.3.Нийслэлийн хэмжээнд Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр арга хэмжээг зохион	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; -Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ		-	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/393 дугаар захирамжаар нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө” болон арга хэмжээнд Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын	100%

1	2	3	4	5	6	7	8	9
		байгуулах					<p>төлөвлөгөөг батлахдаа албан хаагчдаас нэгжийн даргаар дамжуулан санал авч, 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/56 дугаар тушаалын хавсралтаар 5 чиглэлийн 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн төлөвлөгөө болон үндэсний хөтөлбөрийг албан хаагчдад танилцуулсан. Төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 02/1918 дугаар албан бичгээр тайлагнасан. Төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувийн гүйцэтгэлтэй байна.</p>	
		3.4.Хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах	-Сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх.	Жилдээ		-	<p>Байгууллагын дэргэдэх “Эцэг, эхийн зөвлөл”-өөс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтад заасан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30.4 дэх хэсэгт Ажил олгогч, хуулийн этгээд дотооддоо хэрэгжүүлэх байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана” гэж заасны дагуу хүүхэд хамгааллын бодлогыг газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	100%

1	2	3	4	5	6	7	8	9
		<p>3.5.Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөнд санал өгөх, хэрэгжилтийг зохион байгуулах</p>	<p>-Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч нэгтгэн хүргүүлсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	Жилдээ		-	Тус газрын чиг үүрэгт хамааралгүй.	
		<p>3.6.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийх</p>	<p>-Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; -Дүгнэлт зөвлөмж гаргасан байх.</p>	Жилдээ		-	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээний 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 12 ажлыг бүрэн хэрэгжүүлж 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 02/20 дугаар албан бичгээр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт тайлагнасан.</p> <p>-Тус газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/15 дугаар тушаалаар “Хяналт-шинжилгээ, үнэлгээний 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-нд 3 зорилтын 12 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Уг төлөвлөгөөг байгууллагын цахим хуудаст байршуулсан.</p> <p>Төлөвлөгөөний хэрэгжилт 98 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Тайлант хугацаанд бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд 3, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрт 2, худалдан авах</p>	100%

1	2	3	4	5	6	7	8	9
							<p>ажиллагааны эрх шилжүүлсэн захирамжийн хэрэгжилтэд 3, байгууллагын гүйцэтгэлийн тайланд 1, зохион байгуулалтын нэгжийн төлөвлөгөө, тайланд 1, албан бичиг шийдвэрлэлтэд 2, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд 2, мэдээллийн ил тод байдалд 1 удаа тус тус хяналт-шинжилгээ хийсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгавар болон Удирдлагын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгавар, хууль тогтоомжийн хэрэгжилт, сайд нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд тухай бүр хяналт тавин ажиллаж байна.</p>	
		3.7.Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулах	-Эх үүсвэрийн тоог нэмэгдүүлж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулж, 7 хоног тутам мэдээ, мэдээллийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудад танилцуулах.	Жилдээ		-	<p>Тайлант хугацаанд нийт 37 өргөдөл ирснийг тухай бүр 100 хувь шийдвэрлэн хариу өгч ажилласан байна. Өргөдлийг ангилбал:</p> <p>-Үйл ажиллагааны чиглэлээр 9, -Албан хаагчдаас 28 хүсэлт ирүүлснийг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж, хариу хүргүүлсэн байна.</p> <p>Өргөдөл, гомдлын тайланг улирал бүр Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд тайлагнасан. Үүнд:</p> <p>✓ 1 дүгээр улирлын тайланг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 02/846 дугаар албан бичгээр;</p>	80%

1	2	3	4	5	6	7	8	9
							<ul style="list-style-type: none"> ✓ 2 дугаар улирлын тайланг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 02/1997 дугаар албан бичгээр; ✓ 3 дугаар улирлын тайланг 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 02/2570 дугаар албан бичгээр тус тус тайлагнасан. ✓ Жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 28-ны өдөр тайлагнахаар төлөвлөн ажиллаж байна. <p>Тайлант хугацаанд өдөрт нь хүлээн аваагүй, шилжүүлээгүй зөрчил 5 бүртгэгдсэнийг тухай бүр хариуцсан албан хаагчид анхааруулан цаашид алдаа дутагдал гаргахгүй байхыг анхааруулан ажиллан арга зүйн зөвлөгөө өгсөн. 37 өргөдлийг 2 хоног 6 цаг 40 минутад шийдвэрлэн ажилласан.</p>	
		3.8.Нийслэлийн удирдах ажилтны шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг даалгавар, Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах.	-Засаг даргын захирамж, ажлын хэсэг, албан тушаалтанд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцсон байх.	Жилдээ		-	-Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 12 удаа хуралдаж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас тус газрын чиг үүрэгт хамаарах 54 үүрэг даалгавар өгснөөс дундаж хэрэгжилт 94%-ийн гүйцэтгэлтэй буюу “Бүрэн хэрэгжсэн” байна. 54 үүрэг даалгавраас: <ul style="list-style-type: none"> ✓ 51 үүрэг даалгавар “Бүрэн хэрэгжсэн”, 	90%

1	2	3	4	5	6	7	8	9
							<p>✓ 3 үүрэг даалгавар “Хэрэгжих шатанд” байна.</p> <p>“Хэрэгжих шатанд” үнэлэгдсэн үүрэг даалгавар нь жилийн турш хэрэгжих болон тендер шалгаруулалт үргэлжилж байгаа үүрэг даалгаврууд байна.</p> <p>-Газрын “Удирдлагын зөвлөлийн хурал” 15 удаа хуралдаж, газрын даргаас Нийслэлийн шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, эрчимжүүлэхээр 55 удаагийн үүрэг даалгавар өгснийг хариуцсан нэгж, албан хаагчид хэрэгжүүлэн тухай бүр тайлагнасан. Дундаж гүйцэтгэл 95%-ийн гүйцэтгэлтэй буюу “Бүрэн хэрэгжсэн” байна.</p> <p>НЗД-ын 2025 оны А/62 дугаар “Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамжийн биелэлтийг 1-5 дугаар сард 5 удаа ERP цахимаар НЗДТГ-ын ХШҮГ-т тайлагнасан.</p> <p>-Нийслэлийн Архивын газраас 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах, үзлэгийн бэлтгэл ажлыг хангуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн тусалж ажилласан. Холбогдох материал, баримт</p>	

1	2	3	4	5	6	7	8	9
							<p>бичгийг шалгуулсан. Нийслэлийн Архивын газрын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн зөрчил арилгуулах тухай 09/21 дүгээр албан шаардлагыг ирүүлснийг хэрэгжүүлэн 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор тайлагнахаар ажиллаж байна.</p> <p>-2024 онд бүрэн хэрэгжиж дууссан улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдэд Нийслэл дэх төрийн аудит 2025 оны 1 дүгээр улиралд хяналт шалгалтаар ирэхэд худалдан авах ажиллагаатай холбоотой замын 162 төсөл, арга хэмжээний цаасан суурьт 135 хадгаламжийн нэгж, цахим суурьт 307 хадгаламжийн нэгжийг мөн санхүүгийн 29 хадгаламжийн нэгжийг цаг тухайд гарган өгч мэдээллээр ханган ажилласан.</p>	
		3.9.Худалдан авах ажиллагааны АЗ сургалтад хамрагдах албан хаагчийн тоог нэмэгдүүлэх	-Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	Жилдээ	100	-	Худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээ олгох сургалтад хамрагдаж, 2025 оны сүүлийн хагас жилийн байдлаар 36 албан хаагчаас 32 албан хаагч АЗ гэрчилгээтэй бөгөөд гэрчилгээний хугацаа дууссан 1, АЗ шалгалт өгөхөөр бэлтгэж сургалтад хамрагдаж, бие даан судалж буй 3 албан хаагч байна.	90%
		3.10.Байгууллагын төсөв, санхүүгийн	-Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн	Жилдээ		-	2,173,687.5	100%

1	2	3	4	5	6	7	8	9
		сахилга, батыг сайжруулах	тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн сангийн үйл ажиллагаанд хяналтыг тогтмол хийж хэвшсэн байх.				Тайлагнах үеийн байдлаар төсвийн төлөвлөгөөний гүйцэтгэл 92,32 хувьтай байна. Орон нутгийн төсвөөс өссөн дүнгээр 1,753,559.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 1,618,876.6 мянган төгрөгийн зарлага гарч, 134,683.2 мянган төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй ажиллаж байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах 7 арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталж, хэрэгжилтийг ханган ажилласан. Тайлант хугацаанд өр, авлага үүсгэхгүй ажиллаж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр нийт 11 удаа НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст тайлагнасан.	
		3.11.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах	-Нийслэлийн удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалт зохион байгуулсан байх; -Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулсан байх; -Нийслэлийн өмчит,	Жилдээ		-	✓ Тус газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.8 дахь хэсэгт заасны дагуу "Цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахад дэмжлэг үзүүлж, сургалт зохион байгуулах" чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага болон бусад 136	100%

1	2	3	4	5	6	7	8	9
			<p>өмчийн оролцоотой хуулийн этгээдийн албан хаагч нарт зориулсан сургалт зохион байгуулсан байх</p> <p>-Иргэний нийгмийн байгууллага (Иргэн, сонирхлын бүлэг, ТББ, мэргэжлийн холбоо г.м)-д чиглэсэн сургалт зохион байгуулсан байх.</p> <p>-Хувийн хэвшилд зориулсан сургалт зохион байгуулсан байх.</p>				<p>байгууллагуудын 394 албан хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Үүнд:</p> <p>✓ ТБОНӨХБАУХАТХ-ийн танилцуулга сургалтыг Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-тай хамтран Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол дүүргүүдийн Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-ийн бизнес эрхлэгчдэд, Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Зорчигч тээвэр ОНӨААТҮГ, Нийслэлийн нутгийн захиргааны 20 байгууллагын, Улаанбаатар түншлэл төв ХХК, Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газарт дүүргийн 112 төсөвт байгууллага, Ус сувгийн Удирдах газар, Нийслэлийн Бизнес инновацын газарт тус тус газарт сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>✓ Төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналт тавьдаг байгууллагууд болох Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Дүүргийн худалдан авах</p>	

1	2	3	4	5	6	7	8	9
							<p>ажиллагааны албадад 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар санал солилцон, уулзалт, семинар зохион байгуулсан. Тус уулзалтаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалтуудын хэрэгжилтийг хэрхэн хангах, цаашид худалдан авах ажиллагааг амжилттай, гомдол зөрчилгүй зохион байгуулахад анхаарах зүйлсийн талаар зөвлөмж өгч, 2025 оноос эхлэн баримталж буй тендер шалгаруулалтын баримт бичгийг дэлгэрэнгүй танилцуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн.</p> <p>✓ Газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/115 дугаар тушаалаар “Дүүргүүдийн Худалдан авах ажиллагааны албаны үйл ажиллагаанд зөвлөн туслах тухай” ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийн дагуу 14 албан хаагч 2025 оны 09 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд 9 дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын үйл ажиллагаатай танилцан, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.</p>	

1	2	3	4	5	6	7	8	9
							Энэхүү ажлын хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр сургалт зохион байгуулж, тус газрын болон 9 дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны 50 албан хаагч хамрагдсан.	
		3.12.Төрийн болон албаны нууцын тухай, хадгалалт хамгаалалт талаар сургалт зохион байгуулах	-Нийслэлийн удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалт зохион байгуулсан байх; -Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ-ын албан хаагчдад зориулсан зохион байгуулсан байх.	Жилдээ		-	Тус газрын чиг үүрэгт хамаарахгүй.	-
		3.13.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үр дүн тооцох, холбогдох арга хэмжээ авч хариуг хүргүүлэх	-АТГ-аас хүргүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр үр дүнтэй ажиллах, үр дүнг тооцож хүргүүлэх; -АТГ-аас хүргүүлсэн зөрчил арилгуулах албан бичгийн мөрөөр үр дүнтэй ажиллах, үр дүнг тооцож хүргүүлэх; -Тухайн байгууллагатай холбоотой хэвлэл мэдээллийн мөрөөр АТГ-тай хамтран	Жилдээ	Тухай бүр	-	Тайлант хугацаанд АТГ-аас зөвлөмж ирүүлээгүй.	-

1	2	3	4	5	6	7	8	9
			ажиллах, холбогдох баримт бичгийг гаргаж хүргүүлэх; -Тухайн байгууллагын үйл ажиллагаанд тандалт, дүн шинжилгээ хийхэд АТГ-тай хамтран ажиллах, холбогдох баримт бичгийг гаргаж өгөх.					
		3.14.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр батлах дүрэм, журмын жагсаалтыг гаргаж, Авлигатай тэмцэх газраас санал авч, тусгасан байх	-АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, албан бичгийн дагуу хариуг хүргүүлж, өөрчлөх, хүчингүй болгох; -Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч, нэгтгэн хүргүүлсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	Тухай бүр		Тус газраас Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр батлах дүрэм, журмын санал байхгүй.	-
		3.15.Улаанбаатар хотод хэрэгжүүлэх Мега төслүүдийн хэрэгжилтэд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, хяналт тавьж ажиллах	-АТГ-тай хамтран Мега төслүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Жилдээ	Тухай бүр		Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн "Томоохон (мега) төслүүдийн жагсаалт баталж, хэрэгжилт хангуулах тухай" А/277 дугаар захирамжийн 10 мега төслийн хүрээнд Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн 16 захирамжийн 30 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын үнэлгээний	100%

1	2	3	4	5	6	7	8	9
							хороонд томилогдсон гишүүдээс нарийн бичиг тухай бүр Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар"-ын загварын дагуу тухайн худалдан авах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ мэдэгдэх гэж зааснаар бөглүүлэн хууль, журмын хэрэгжилтийг ханган ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.	
Дундаж хэрэгжилт								95%

ТАНИЛЦСАН:
 ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
 ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
 ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
 ХЭЛТСИЙН ДАРГА

ХЯНАСАН:
 ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНӨЛГЭЭ
 ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
 ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН



Д.БАТЦЭЦЭГ

Ө.ОЮУНЧИМЭГ

Б.ОТГОНСҮРЭН